

“АЖ АХУЙ НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1. Хууль зүйн шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн эрх тэгш хөгжлийг хангах, зах зээлийн эдийн засгийн харилцааг зохицуулах үүрэгтэй гэж заасан. Мөн Үндсэн хуулийн 58 дугаар зүйлд аймаг, нийслэл, сум, дүүрэг нь өөрийн удирдлагатай байх, орон нутгийн эдийн засаг, нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэх зарчим тусгагдсан. Энэхүү зарчим бодитоор хэрэгжихийн тулд орон нутаг санхүүгийн хувьд бие даасан, урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй байх шаардлагатай. Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд төсвийн сахилга бат, хөрөнгийн зах зээлийн хөгжил, татварын бодлогоор эдийн засгийн зөв урамшуулал бий болгох зарчим тусгагдсан.

Одоогийн зохицуулалтаар Засгийн газар, Нийслэл, Монгол Улсын Хөгжлийн банкны бондын хүүгийн орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх боломжтой боловч төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт орлого төвлөрүүлдэг аймгийн гаргасан үнэт цаасны хүүгийн орлогод ийм татварын зохицуулалт үйлчлэхгүй байна.

Иймд орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, орон нутгийн бондын зах зээлийг бий болгох, урт хугацааны дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах хууль зүйн шаардлага үүсэж байна.

2. Практик шаардлага

Монгол Улсын төсвийн тогтолцоо өнөөдөр хэт төвлөрсөн хэвээр байна. Олон аймгийн төсвийн орлогын томоохон хэсгийг улсын төсвөөс олгодог санхүүгийн дэмжлэг, шилжүүлэг бүрдүүлж байгаа нь орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг хязгаарлаж байна.

Орон нутгийн төсөв улсын төсвөөс хэт хамааралтай байх нь тухайн аймаг өөрийн хөгжлийн бодлого, дэд бүтэц, үйлдвэрлэл, логистик, эрчим хүч, аялал жуулчлалын төслөө урт хугацаанд бие даан төлөвлөж хэрэгжүүлэх боломжийг багасгаж байна.

Нөгөө талаас Монгол Улсын хөрөнгийн зах зээл, ялангуяа бондын зах зээл сул хөгжсөн хэвээр байна. Дотоодын урт хугацааны хөрөнгө оруулалтын хэрэгсэл цөөн, санхүүжилт банкны зээлд хэт төвлөрсөн байгаа нь эдийн засгийн санхүүжилтийн бүтцийг эмзэг болгож байна.

Орон нутгийн засаг захиргааны байгууллага үнэт цаас гаргах замаар хөрөнгө татах боломжтой боловч татварын урамшуулал, эрх зүйн тодорхой орчин хангалтгүйгээс хөрөнгө оруулагчдын сонирхол сул байна. Үүний улмаас орон нутгийн хөгжлийн төсөл, дэд бүтэц, үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт улсын төсөв, төсвийн шилжүүлгээс хэт хамааралтай хэвээр байна.

Олон улсын туршлагаас үзэхэд АНУ, Канад, БНСУ, Энэтхэг, Бразил зэрэг улс орнууд орон нутгийн бондын зах зээлийг татварын бодлогоор дэмжиж, дэд бүтэц, нийтийн үйлчилгээ, үйлдвэрлэл, бүс нутгийн хөгжлийн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр болгон ашиглаж ирсэн байна.

Монгол Улсын хувьд улсаас байнга татаас авдаг орон нутгийг бус, харин өөрийн орлогоор төсвөө бүрдүүлэх чадвартай, санхүүгийн сахилга баттай аймаг, орон нутгийг татварын бодлогоор урамшуулах шаардлагатай юм. Энэ нь орон нутгийг “татаас хүлээгч” бус “хөрөнгө татагч” болгох бодлогын өөрчлөлт болно.

Иймд төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт орлого төвлөрүүлдэг аймгийн гаргасан үнэт цаасны хүүгийн орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх замаар хөрөнгө оруулагчдын сонирхлыг нэмэгдүүлэх, орон нутгийн бондын анхны эрэлтийг бий болгох, санхүүжилтийн өртгийг бууруулах практик шаардлага тулгарч байна.

Хоёр. Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулах бөгөөд уг хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгана.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтын “Засгийн газар, Нийслэл, Монгол Улсын Хөгжлийн банкны бондын хүү” гэсний дараа “төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт орлого төвлөрүүлдэг аймгийн гаргасан үнэт цаасны хүү” гэж нэмнэ.

Энэхүү зохицуулалт нь зөвхөн санхүүгийн сахилга баттай, өөрийн орлогоор төсвөө бүрдүүлэх чадавхтай аймгийн гаргасан үнэт цаасанд хамаарах бөгөөд татварын хөнгөлөлтийг дур зоргоор, бүх орон нутагт хавтгайруулан хэрэглэхгүй байх зарчмыг баримтална.

Аймгийн гаргах үнэт цаас нь Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн байх, өрийн сахилга бат, санхүүгийн тайлагнал, аудит, хөрөнгө оруулалтын зориулалт нь ил тод байх шаардлагатай гэж үзнэ.

Хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгав.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар орон нутгийн санхүүгийн эх үүсвэр төрөлжиж, аймаг, орон нутгууд хөрөнгийн зах зээлээс урт хугацааны санхүүжилт татах боломж бүрдэнэ.

Төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт орлого төвлөрүүлдэг аймгийн гаргасан үнэт цаасны хүүгийн орлогыг татвараас чөлөөлснөөр хөрөнгө оруулагчдын өгөөж нэмэгдэж, орон нутгийн бонд худалдан авах сонирхол өснө. Үүний үр дүнд орон нутгийн үнэт цаасны зах зээл бүрэлдэх, банк, даатгал, хөрөнгө оруулалтын сан зэрэг институцийн хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.

Орон нутгийн бондоор татсан хөрөнгийг дэд бүтэц, үйлдвэрлэл, логистик, эрчим хүч, ус хангамж, зам тээвэр, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн өгөөжтэй төслүүдэд чиглүүлснээр орон нутгийн эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, ажлын байр бий болох, татварын суурь өргөжих, бүс нутгийн хөгжлийн ялгаа буурах эерэг үр нөлөө гарна.

Богино хугацаанд улсын төсөвт төвлөрөх боломжтой тодорхой хэмжээний татварын орлого буурах эрсдэлтэй. Гэвч энэ нь нийт татварын орлогын маш бага хэсгийг эзлэх бөгөөд дунд, урт хугацаанд хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, ажлын байр, татварын суурь нэмэгдэх замаар нөхөгдөх боломжтой бодлогын зардал гэж үзнэ.

Хуулийн төсөл хэрэгжих явцад орон нутгийн өрийн сахилга бат сулрах, санхүүжүүлсэн төслийн үр ашиг хангалтгүй байх, тайлагнал ил тод бус байх, хөрөнгө оруулагчдын эрсдэлийн үнэлгээ сул байх зэрэг эрсдэл үүсэж болзошгүй.

Эдгээр эрсдэлийг бууруулахын тулд Сангийн яамны урьдчилсан зөвшөөрөл, өрийн дээд хязгаар, төслийн эдийн засгийн үндэслэл, зээлжих зэрэглэл, аудит, тайлагнал, олон нийтэд мэдээлэх ил тод байдлын шаардлагыг хамтад нь хэрэгжүүлэх шаардлагатай.

Ингэснээр уг татварын хөнгөлөлт нь төсвийн сахилга батыг сулруулах бус, харин санхүүгийн сахилга баттай орон нутгийг урамшуулах, хөрөнгийн зах зээлийн зөв бүтээгдэхүүн бий болгох, орон нутгийг төвлөрсөн төсвөөс хараат байдлаас аажмаар гаргах бодлогын хэрэгсэл болно.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсрууллаа.

Хуулийн төсөл нь орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, төсвийн төвлөрлийг бууруулах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, дотоодын урт хугацааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх олон улсын сайн туршлагатай нийцнэ.

Тус хуулийн төсөлтэй уялдуулан шаардлагатай тохиолдолд орон нутгийн үнэт цаас гаргах журам, өрийн удирдлагын хяналтын механизм, санхүүгийн тайлагнал, аудит, хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх стандарт, орон нутгийн бондын зориулалт, хязгаарлалттай холбоотой эрх зүйн актыг боловсронгуй болгоно.

Мөн хуулийг хэрэгжүүлэх